

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН 2014 ОНЫ 225 ДУГААР ТУШААЛД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

**А. Ерөнхий мэдээлэл**

1.	Актын оноосон нэр, дүрэм журмын бүтэн нэрийг бичих	“Журам батлах тухай” Зам, тээврийн сайдын тушаал, “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”
2.	Үндэслэл болгосон хуулийн заалт, эсвэл эрх зүйн бусад акт /заалтыг бүтнээр бичих/	Төмөр замын тээврийн тухай хуулийн 10.1.3, 15.1.16-д заасныг үндэслэсэн.  Хуулийн 10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:  10.1.3. төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг батлах;  Хуулийн 15.1.Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр дараахь журмыг тогтооно:  15.1.16. төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам;
3.	Хамтран баталсан субъект	-
4.	Баталсан огноо	2014 оны 10 дугаар сарын 06
5.	Дугаар	225
6.	Улсын нэгдсэн санд бүртгэгдсэн огноо, бүртгэлийн дугаар	ХЗЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 3507 дугаарт бүртгэгдсэн
7.	Нэмэлт, өөрчлөлт орсон тухай мэдээлэл	-
8.	Зохицуулах харилцааны ерөнхий агуулга /шийдвэрийн зорилтын томъёолол/	Хөдөлгөөн зохицуулалтын төв, төмөр замын байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцох, түүнтэй холбогдон гарах төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулсан
9.	Үйлчлэх хүрээ /нутаг дэвсгэр, салбар/	Хөдөлгөөн зохицуулалтын төв, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд
10.	Үйлчлэх хугацаа	Хугацаа заагаагүй

**Б. Хяналт-шинжилгээ хийсэн үзүүлэлт**

	Захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлага	Тухайн шаардлагад нийцэж буй эсэх	Тайлбар
1.	Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд нийцсэн эсэх	Нийцсэн	-
2.	Тусгайлан эрх олгосон тухай хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн эсэх	Нийцээгүй	Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12-т төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх бүрэн эрхийг төмөр замын асуудал

			эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр заасан
3.	Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх	Хуулийн заалтыг заасан	-
4.	Шийдвэрийн заалт хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх	Зөрчилдөж байгаа	Зам, тээврийн сайдын 2014 оны 225 дугаар тушаалаар батлагдсан Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын 1.3, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан төвийн дүрмийн 4.2.25 дахь заалт нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалттай зөрчилдсэн
5.	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх	Төмөр замын тээврийн тухай хуульд заасан нэр томъёог Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журамд хэрэглэсэн	-
6.	Хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх	-	-
7.	Тухайн шийдвэрээр урьд нь гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг тусгасан байх	-	-
8.	Бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд ишлэл хийгдсэн байх	Ишлэл хийгдсэн	Журмын 1.2-т Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуулийг иш татсан.
9.	Баталсан байгууллага, албан тушаалтны болон захиргааны хэм хэмжээний актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх	Зам, тээврийн сайдын 2014.10.06-ны өдрийн 225 дугаар тушаалаар батлагдсан	
10.	Хуульд заасан бусад шаардлага	-	-

## В. Дүгнэлт санал

1.	Үндэслэл болгосон хуулийн заалт болон уг хууль хүчинтэй эсэх	2007 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Төмөр замын тээврийн тухай хуулийг мөн өдрөөс дагаж мөрдсөн. Хүчинтэй.
2.	Улсын нэгдсэн санд бүртгэлтэй уг акт хүчинтэй хэвээр үйлчилж байгаа эсэх /эсхүл хүчингүй болсон бол тэр талаар мэдэгдэх/	Хууль зүйн яамны улсын нэгдсэн бүртгэлийн 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 3507 дугаарт бүртгэгдсэн Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам хүчинтэй хэвээр үйлчилж байна
3.	Бусад	1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн ... –д заасан бүрэн эрхээс бүрэн буюу хэсэгчлэн хөдөлгөөн

		<p>зохицуулалтын төвд шилжүүлж болно гэсэн зохицуулалтыг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах;</p> <ol style="list-style-type: none"><li>2. Журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах;</li><li>3. Төмөр замын байгууллагын сар, улирал, хагас, бүтэн жилийн статистик мэдээг дараа сарын 10-ны дотор хөдөлгөөн зохицуулалтын төвд ирүүлэхээр журамласан. “УБТЗ” ХНН-ийн аж ахуйн нэгж, өртөө, зөрлөгөөс мэдээ бүрдүүлж, нэгтгэн ирүүлдэг учир хугацаа шаардагддаг, тиймээс энэхүү хугацааг 15-ны дотор байхаар өөрчлөх;</li><li>4. Зам, тээврийн сайдын 2015 оны 347 дугаар тушаалаар батлагдсан төмөр замын тээврийн захиргааны статистикийн ТЗ-3, журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан Галт тэрэгний зурмаг тасалдлын хоногийн мэдээ №6 маягыг шинэчлэх;</li><li>5. Тус журмаар Хөдөлгөөн зохицуулалтын төв, төмөр замын байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцохоор заасан нь хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагын мэдээлэл орхигдож байгаа учир тэдгээр байгууллагаас мэдээ солилцдог зохицуулалтыг шинээр тусгах;</li><li>6. Цахим болон тусгай програм хангамжийн тусламжтай статистик мэдээ мэдээллийг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглах эрх зүйн орчны суурь түвшинг нэмэлтээр оруулах.</li></ol>
--	--	---